

**“ЖИДАКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 03-р сарын 17-ны өдөр

Дугаар 25/02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

“Жидакс” ХК-ийн 2025 оны 03-р сарын 17-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын хоёрдугаар тэмдэглэл, компанийн тухай хуулийн 59.4, 62.1.15 дугаар зүйлийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

**Нэг.** “Жидакс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04-р сарын 28-ны өдөр 14.00 цагт, Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16-р хороо, орхон-1, Шинэ Монгол Хаад Групп ХХК-ийн байр, 2-р давхарын хурлын танхимд хуралдуулсугай. Хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Т.Төгс-Од даргалсугай.

**Хоёр.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04-р сарын 07-ны өдрөөр тогтоож, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид 2025 оны 03-р сарын 19-ний өдөр хүргүүлэн, хурлын товыг Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу 2025 оны 03-р сарын 21-ний өдөр, 2025 оны 04-р сарын 03-ны өдрүүдэд олон нийтэд зарласугай.

**Гурав.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2025 оны 03-р сарын 28-ны өдрийн дотор брокер дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхээр тогтоосугай.

**Дөрөв.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

**Тав.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтуудын жагсаалт, уг бичиг баримтуудтай танилцаж болох газар, хугацааг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

**Зургаа.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг гуравдугаар хавсралтаар баталсугай.

**Долоо.** Хурлын өдөр ирсэн хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авахаас гадна брокер дилерийн компаниар дамжуулан урьдчилан санал авах сүүлчийн өдрийг 2025 оны 04-р сарын 23-ны өдрөөр тогтоож, санал авах хуудасны агуулга, загварыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.

**Найм.** Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах хэвлэлийн эхийг тавдугаар хавсралтаар баталсугай.

**Ес.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, хурлыг зохион байгуулах, хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангаж ажиллахыг даалгасугай.

Зохион байгуулах комиссын дарга: Т.Төгс-Од

Гишүүн: Д.Булгамаа

**Арав.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилж, даалгах ажлыг зургаадугаар хавсралтаар баталсугай.

Тооллогын комиссын дарга: Э.Хашмаргад

Гишүүн: Б.Даваажаргал

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



Т.ТӨГС-ОД